



**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Г Сургалт зохион байгуулах тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч нарт аюулт үзэгдэл, осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 3.240.000 (гурван сая хоёр зуун дөчин мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалтын бэлтгэлийг хангаж, хугацаанд нь зохион байгуулахыг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт, сургалтын явцад хяналт тавьж ажиллахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн  
А/107 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БОЛОН ТЭДНИЙ АСРАН ХАМГААЛАГЧ  
НАРТ ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Сургалтын зорилго.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт гамшиг осол, гал түймэр, ахуйн болон техникийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр мэдээлэл өгч, анхан шатны мэдлэг олгоход оршино.

Хоёр. Сургалт зохион байгуулах бүрэлдэхүүн.

Сургалтыг Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн нар зохион байгуулна.

Сургалтыг зохион байгуулахдаа дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллана.

Гурав. Сургалтын хамрах хүрээ.

д/д	Дүүрэг	Сургалтанд хамруулах		
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	ХБИ-ийг асран хамгаалагч	Нийт
1	Баянзүрх дүүрэг	30	20	50
2	Баянгол дүүрэг	30	20	50
3	Сүхбаатар дүүрэг	30	20	50
4	Сонгинохайрхан дүүрэг	30	20	50
5	Хан-Уул дүүрэг	30	20	50
6	Чингэлтэй дүүрэг	30	20	50
	Нийт	180	120	300

Дөрөв. Сургалт зохион байгуулах газар, хугацаа

Сургалт зохион байгуулах газрыг тухайн дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй зөвшилцөж тогтооно.

Сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулна.

## Тав.Сургалтын үйл ажиллагаа, үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт Иргэд олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох “Бэлэн бай” сургалтын багцыг ашиглан танхимын сургалт явуулж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр анхан шатны мэдлэг олгосон байна.

## Зургаа. Тайлан мэдээ ирүүлэх

Сургалтын нэгдсэн илтгэх хуудсыг файлаар 2019 оны 10 дугаар сарын 4-ний өдөрт багтаан [nobg.surgalt@gmail.com](mailto:nobg.surgalt@gmail.com) хаягаар, 10 дугаар сарын 07-ны өдөр баталгаажуулсан хувийг хамрагдсан иргэдийн нэрсийг хавсаргаж тус тус Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст ирүүлнэ.

--o0o--

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн  
А/107 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт /төгрөг/
1	Хоол	ш	6.500	300	1.950.000
2	Кофе	ш	300	600	180.000
3	Печень, цайны боов	ш	500	600	300.000
4	1 удаагийн аяга	ш	150	600	90.000
5	Дэвтэр	ш	1.500	300	450.000
6	Үзэг, бал	ш	900	300	270.000
Нийт					3.240.000

--ооо--